



ДАРХАН-УУЛ АЙМАГ  
“ДАРХАНЫ ДУЛААН СҮЛЖЭЭ” ТӨХК-НИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 15 өдөр

Дугаар 2/86

Дархан

Жилийн ажлын тайлан бичих, хамгаалах,  
дүгнэх, урамшуулах, хариуцлага тооцох журам

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.10, Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.3, “Дарханы дулааны сүлжээ” ТӨХК-ийн хөдөлмөрийн дотоод журмын 3.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Дарханы дулааны сүлжээ” ТӨХК-ийн жилийн ажлын тайлан бичих, хамгаалах, дүгнэх, урамшуулах, хариуцлага тооцох журмыг хавсралтаар баталсугай.

2. Энэ журмыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

3. Энэ журмыг нийт ажилтнуудад сурталчлан танилцуулахыг Захиргаа удирдлагын хэлтсийн дарга (Ч.Чүлтэмтат)-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Д.БАТЖАРГАЛ



3.5 Тайлан хамгаалахаар бэлтгэсэн материал нь тодорхой биш, судалгаа, үнэлэлт, дүгнэлтгүй бол шаардлага хангаагүй гэж үзээд буцаана.

#### Дөрөв. Дүгнэх

4.1 Тайлан хамгаалалтыг дүгнэхдээ хавсралт №1-д заасан үзүүлэлт тус бүрээр 0-100 хувиар дүгнэнэ. /Тайланд өгсөн үнэлгээг 2.1.2-2.1.6-д заасан тусгах ёстой агуулга тус бүрийг харгалзуулж үнэлнэ./

4.2 Тайлан дүгнэхэд оролцсон гишүүн тус бүрийн оноог нэгтгэж, дундаж онооны аргаар тооцон эцсийн дүнг гаргаж дараах үнэлгээг өгнө.

4.2.1 Дундаж оноо нь 0-64 бол "Хангалтгүй" үнэлгээ

4.2.2 Дундаж оноо нь 65-84 бол "Хангалттай" үнэлгээ

4.2.3 Дундаж оноо нь 85-100 бол "Бүрэн хангалттай" үнэлгээг тус тус өгнө.

#### Тав. Урамшуулах, хариуцлага тооцох

5.1 Тайлан хамгаалалтын үнэлгээ 65 хувиас дээш үнэлгээгээр дүгнэгдсэн ажилтнуудыг тухайн ажлын байранд тэнцсэн гэж үзэж жилийн үр дүнгийн шагнал авах эрх үүснэ.

5.2 Тайлан хамгаалалтын үнэлгээ 95 хувиас дээш үнэлгээгээр дүгнэгдсэн ажилтнуудыг урамшуулж жилийн үр дүнгийн шагналыг компанийн жилийн үр дүнгийн шагнал олгох дээд хэмжээгээр олгоно.

5.3 Тайлан хамгаалалтанд "Хангалтгүй" үнэлгээ авсан бол "ДДС" ТӨХК-ийн хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу шийдвэрлэнэ.

#### Зургаа. Журмыг хэрэгжүүлэх

6.1 Тайлан хамгаалалтын комиссын нарийн бичиг тайлан хамгаалалтын үнэлгээг нэгтгэж, Захиргаа удирдлагын хэлтэст хүргүүлж, Захирлын зөвлөлд танилцуулж, шийдвэр гаргуулан тайлангийн мөрөөр урамшуулах, хариуцлага тооцох арга хэмжээг хэрэгжүүлнэ.

